

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ЖАГСААЛТ
2025 ОНЫ БИЕЛЭЛТ

2025.12.12

№	Төрөл	Агуулга, заалт	Хэрэгжилтийн явц
1	ЗДҮАХ-ийн заалт	2.2.3.2. Нойрны дутагдлаас үүссэн мэдрэлийн ядаргаа, сэтгэл түгшилт, сэтгэл гутралаас сэргийлэх, уур бухимдал тайлах идэвхтэй аргуудыг сурч, сэтгэл хөдлөлийн ур чадваруудыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлнэ	“Сэтгэцийн эрүүл мэнд” 2024-2027)- дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд СЭМҮТ-ийн төвтэй хамтран Даланзадгад сумын 3, 5, 6-р сургуулийн нийт 679 хүүхдэд цахим халдлага, хүчирхийлэл ялгаварлан гадуурхах дээрэлхэх, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, хорт зан үйлээс ангид байх нь сэдвээр сургалт зохион байгуулж сэтгэцийн эрүүл мэндийн нөлөөллөөс үүдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон гэр бүлийн асран хамгаалагчдад 50 хүнд тандалт судалгаа, сургалт арга хэмжээг зохион байгуулсан. Итгэлтэй дүүрэн амьдрал ОНӨААТҮГ нь 2025 онд нийт 639 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс амбулаторийн тусламж үйлчилгээг 354 хүнд, Хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг 285 хүнд үзүүлсэн байна. АЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэс орон нутгийн цагдаагийн хэлтэстэй хамтран “Нөлөөллийн арга хэмжээ” үйл ажиллагааг зохион байгуулж Даланзадгад сумын 20 иргэн, Цогтцэций сумын 20 иргэн, бусад сумдын 20 иргэн нийт 60 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулан эмчилгээ үйлчилгээ хийсэн. Итгэлтэй амьдрал ОНӨААТҮГ-н эмч сувилагч сэтгэл зүйч нар Ханхонгор, Сэврэй, Гурвантэс, Цогтцэций сумын 209, аймгийн төвийн 4 багийн 304 хүнийг “Архины хэрэглээ түүний хор уршиг” “Гэр бүлийн зан үйлийн эерэг нөрөө” г.м сургалтад хамруулсан байна. Аймгийн хэмжээнд 11 дүгээр сарыг сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг иргэн бүрд аяныг Боловсролын газартай хамтарч ЕБС-ийн багш ажилчид, сурагч нарт “Сэтгэцийн эрүүл мэндээ дэмжье” нэртэйгээр зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 2100 гаруй хүнд хүрч сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.

			Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төв дээр мэргэжлийн сэтгэл зүйч орон тоогоор ажилснаар 21 иргэн, өсвөр насны 16 хүүхдэд 150 гаруй удаагийн давтамжтайгаар ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг өгсөн. ЕБС-ийн дунд, ахлах, ангийн сурагчдын анги бүлэгт "Дэлгэцийн хэрэглээг хянах, багасгах" сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор "УТАСГҮЙ БУЛАН"-г Даланзадгад сумын ЕБС-ын 21 ангийн 640 орчим сурагчдад нэвтрүүлсэн. Хэрэгжилт-100 хувь
2	ЗДҮАХ-ийн заалт	2.2.3.1. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, нойрны дутагдлаас үүссэн мэдрэлийн ядаргаа, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжих арга хэмжээг зохион байгуулна.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг иргэд, төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, сэргийлж болох өвлөл, нас баралтыг бууруулах хүрээнд 9 удаагийн арга хэмжээ зохион байгуулан 8,763 хүнийг хамруулсан. Үүнд:Гурвантэс, Ноён, Сэврэй, Ханбогд, Баян-Овоо, Мандал-Овоо, Цогтцэций, Хүрмэн, Даланзадгад сумдад явуулын сургалт нөлөөллийн цогц арга хэмжээг зохион байгуулан сэргийлж болох өвлөл түүнээс шалтгаалсан нас баралтыг бууруулах урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдол, товллолын дархлаажуулалт, зөв хооллолт, хеликобактерийн халдвараас сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тухай ойлголт сэдвүүдээр сургалт нөлөөллийн арга хэмжээг танхимаар зохион байгуулж иргэдийн эрүүл мэндийн боловсролын нэмэгдүүлсэн. Сургалтын тоо-10 Хамрагдсан хүний тоо-8,790 Аймгийн 22 эрүүл мэндийн байгууллага ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн 40 гаруй арга хэмжээг зохион байгуулж 11000 гаруй иргэнийг хамруулсан. Бусад салбарын хамтын ажиллагааны хүрээнд нийт 60 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын фейсбүүк хуудсаар дамжуулан 1500 төрлийн мэдээлэл, нийтлэлийг хүргэж давхардсан тоогоор 350,000 хүний хандалт авсан. Өмнөговь аймгийн Засаг даргын санаачилсан "Электрон тамхинаас татгалзаж, ирээдүйгээ хамгаалцгаая" аяныг 1 сарын хугацаанд зохион байгуулагдан аянд хамтарч ажилласан. Аяны хүрээнд 3 сум, 6 сургуулийн 1000 орчим сурагчдад электрон тамхины хор хөнөөлийн талаар сургалтыг зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд Дугуйтай аян, Завсарлагааны хэмнэл аян, Шүдээ угаах

			24/3 аян зэрэг томоохон аяныг зохион байгуулж Мөн аймгийн хэмжээнд сар бүр “Эрүүл мэндийг дэмжих өдөр” арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж нийт 110 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг хийж 4146 хүнд хүрч ажилласан байна. Нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр аймгийн 43 спорт заал, 2 усан бассейн, 5 фитнес клуб, 4 иог, бясалгалын төв, 2 бүжгийн клуб зэрэг нийт 56 байгууллага аж ахуй нэгжтэй хамтран хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжин ажиллаж байна. хэрэгжилт -100 хувь
3	ЗДҮАХ-ийн заалт	2.2.3. Иргэдийг эрүүл дадал, хэвшил, амьдралын идэвхтэй хэв маягийг хэвшүүлэх бодлого хэрэгжүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгийн хүрээнд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлээр аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 7 төрлийн төсөл арга хэмжээг тусган шаардлагатай 1.0 тэрбум гаруй төгрөгийг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болох нас баралт, өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болох хавдрын өвчлөл, элэг, амны хөндийн өвчлөлийн тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар Эрүүл элэг, Эрүүл шүд, Эх хүүхдийн эрүүл мэнд, Сүү тараг хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 90%-ийн биелэлттэй, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Аймгийн 22 эрүүл мэндийн байгууллага ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн 330 гаруй арга хэмжээг зохион байгуулж 19902 иргэнийг хамруулсан. Бусад салбарын хамтын ажиллагааны хүрээнд нийт 150 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын фейсбүүк хуудсаар дамжуулан 3000 орчим төрлийн мэдээлэл, нийтлэлийг хүргэж давхардсан тоогоор 500,000 хүний хандалт авсан байна. Аймгийн хэмжээнд Дугуйтай аян, Завсарлагааны хэмнэл аян, Шүдээ угаах 24/3 аян, Эрсдэлгүй ирээдүй аян, Дархлаажуулалтын аян зэрэг томоохон аяныг зохион байгуулж байна. 2025 онд сургууль, цэцэрлэгийн хүрээнд "Энэ жилдээ Эрүүл жиндээ" хатариш бүжгийн аяныг зохион байгуулж 12 сургууль 15 цэцэрлэг идэвхтэй оролцож хүүхдүүдэд эрүүл дадал хэвшлийг сурталчилж, уриалж ажилласан.

			хэрэгжилт 100 хувь байна.
4	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.8. Алсын зайн оношилгооны төв байгуулж үндэсний төвүүдтэй холбоно.	Сумын эрүүл мэндийн төв-14, Өрхийн эрүүл мэндийн төв-3 нийт анхан шатны 17 байгууллага өндөр хурдны интернэт 100 хувь холбогдож Телемедицинийг шаардлагатай тохиолдолд ашиглах шаардлагыг бүрэн хангасан. Сумын эрүүл мэндийн төвүүд шаардлагатай тохиолдолд лавлагаа шатны эмнэлгээс телемедицин ашиглан эмнэлзүйн зөвлөгөө, зөвлөмжийг авч ажиллаж байна. хэрэгжилт -100 хувь
5	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.7. Эрүүл мэндийн байгууллагуудыг ойрын болон алсын зайн дуудлагын түргэн тусламжийн авто машинаар хангана.	Орон нутгийн төсвөөр Тендерийн 1-р багц болох түргэн тусламжийн тоноглогдсон автомашинуудыг Сэврэй, Баян-овоо, Баяндалай ,Хүрмэн сумдад “Ханбогд арвижих” ХХК 843,7 сая төгрөгийн төсвөөр 8 сард нийлүүлэгдэнэ. 2-р багц ЭМГ-т туулах чадвар бүхий автомашиныг “Мансон” ХХК 278,3 сая төгрөгөөр 3-р багц болох ЗӨСТ төвийн автомашиныг “УАЗ мега” ХХК 143,8 сая төгрөгийн төсвөөр тус тус нийлүүлэгдсэн. хэрэгжилт -100
6	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.6. Цахим эрүүл мэндийн системийг хөгжүүлж, үйлчилгээний шуурхай байдал, эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Эрт илрүүлэг хийж байгаа БОЭТ-“E-Health, 17-сум өрхийн эрүүл мэндийн байгууллага. vhs.hinfo.mn программыг 100 хувь ашиглаж үзлэгийн мэдээгээ оруулж байна. Статистик мэдээ мэдээллийн хүрээнд эрүүл мэндийн салбарын СЭМТ-14, ӨЭМТ-3, БОЭТ-1 хувийн хэвшлийн 22 эмнэлэг, цэргийн ангийн 3 эмнэлэг, “h info” программыг 100 хувь ашиглаж байна. Эрүүл мэндийн газарт аймгийн хэмжээний халдварт өвчний мэдээлэл бүртгэх “e-wag” программыг ашиглаж ЭМБ-ууд сарын мэдээний хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим программыг тус тус ашиглаж байна. 2015 оны 12 сарын 11-ний байдлаар 781 халдварт өвчин бүртгэн мэдээлсэн. Томуугийн үндэсний төвийн flu.mn программыг анхан шатны 17 ЭМБ-ууд БОЭТ бүрэн ашиглан 25,440 өвчлөл бүргэн мэдээлсэн байна. Нийт эрүүл мэндийн салбарын статистик мэдээ мэдээлэлд-5 программ ашиглаж байна. Цаашид эрүүл мэндийн салбарын статистик мэдээлэлд

			ашиглах программ хангамжийг ЭМХТ-өөс хөгжүүлэлт хийгдэж байна. хэрэгжилт -100 хувь
7	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.5. Улаанбаатар хотод Өмнөговь аймгийн иргэдэд эрүүл мэндийн зөвлөн, зуучлах үйлчилгээг үзүүлнэ.	2025 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 50 сая төгрөг баталсан бөгөөд 2025 оны хагас жилийн төсвийн тодотголоор тухайн төсвийг хассан ажил хийгдээгүй
8	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.4. Сум, сум дундын эмнэлгүүдийн чанар, хүртээмжийг сайжруулж, яаралтай түргэн тусламжийн "Нисдэг баг" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2025 онд эхийн 11 сарын байдлаар эхийн ноцтой хүндрэл 2 бүртгэгдсэн. Тус тохиолдлуудад БОЭТ-ийн хамт олон чанартай тусламж үйлчилгээг үзүүлж, ЭХЭМҮТ-өөс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, газар дээр нь тусламж үйлчилгээг амжилттай үзүүлэн ажилласан. 2025 оны 11 сарын 29-нд 23-24 долоо хоногтой эхийг иргэнээс-2,8 сая, нисдэг баг АЗДТГ-с 15 сая төгрөгөөр ЭХЭМҮТ-д хүргэсэн. эх хүүхдийн биеийн байдал сайн байна. хэрэгжилт-100 хувь
9	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.3. Гадаад, дотоодод нарийн мэргэжлийн өндөр үнэ өртөгтэй эмчилгээ оношилгооны орчин үеийн дэвшилтэт техник, технологи багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2025 онд ЭМБ-уудыг ЭТТөхөөрөмжөөр хангах чиглэлээр нийт 4,5 тэрбум төгрөгийн төсөв бүхий 8 худалдан авалт төлөвлөгдсөнөөс 4-р улирлын байдлаар бүх ажлын тендер зарлагдан 7 ажлын гэрээ хийгдэж, үүнээс 7 ажил гэрээний дагуу хүлээлгэн өгсөн. - Баян-Овоо сумын ЭМТ-д 450 сая төгрөгийн төсвөөр өнгөт ЭХО аппарат нийлүүлэх ажлын гэрээ хийгдээгүй төсөв татагдсан. 1. ОНТ 50 сая төгрөгийн санхүүжилтээр Эрүүл шүд хөтөлбөрийн хүрээнд шүдний төвийг 4 нэр төрлийн ТТ, 12ш хамгаалах хэрэгслээр 2. ОНТ 850 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-д ЭХО аппарат-2ш дагалдах хэрэгслийн хамт, 8 ЭМБ-д 19 нэр төрлийн 28ш эмнэлгийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжүүд 3. ОНТ 1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн гемодиализийн тасагт нэн шаардлагатай гемодиализийн аппарат, усны систем, Ангиографын аппаратыг үйл ажиллагаанд оруулах засварын ажил, шаардлагатай тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл, ү/а-ы зардал. 4. ОНТ 35 сая төгрөгийн санхүүжилтээр ЗӨСТөвд 7 нэр төрлийн 8ш лабораторын болон хэмжилтийн тоног төхөөрөмж

			5.ОНТөсвөөр 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх зорилгоор "Нүүдлийн клиник" иж бүрэн тоноглогдсон автомашин 6. говийн оюу хөгжлийн дэмжих сангийн 80.0 төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн эрт илрүүлгийн нэгжид нэн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл 7. говийн оюу хөгжлийн дэмжих сангийн 82.600.000 төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн Диабетиин төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн. хэрэгжилт 100 хувь
10	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.2. Эмнэлгүүдийг өргөтгөх болон шинээр эмнэлэг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	-Орон нутгийн төсвийн 400,000,000 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн 75 ортой эмнэлэг, амбулаторийн барилгын дээврийг засварлах ажлыг “Зам Бүрд Констракшн” компани хийж гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгсөн. -Орон нутгийн төсвийн 230,000,000 сая төгрөгийн санхүүжилтээр Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн хуучин эмнэлгийн барилгын засварын ажлыг Девсофт ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. -Орон нутгийн төсвийн 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвийн эмч нарын орон сууцны засварын ажлыг “Баян Сувд Эрдэнэ” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. -Орон нутгийн төсвийн 75,000,000 сая төгрөгийн санхүүжилтээр Ханхонгор сумын эрүүл мэндийн төвийн амбулаторийн склад, эхийн амрах байрны барилгын дээврийг засварлах ажлыг “Эрдэнэсийн Сан Өв” ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн амбулаторийн барилгын дээврийн засварын ажлыг 145 сая төгрөгийн санхүүжилтээр “Хөрхдөр хан” ХХК хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн. -Баяндалай сумын эмч нарыг байрны засвар, Ханбогд сумын ажилчдын орон сууцны засвар, Баян-Овоо сумын эмнэлгийн байрны засварын ажлыг тухайн сумдын Засаг даргын Тамгын газарт эрхийг шилжүүлсэн. Хэрэгжилт 100 хувь

11	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2.1. Эрүүл мэндийн салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх, чадваржуулах, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулна.	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн стандарт хангалт 2025 оны 12 сарын байдлаар 85,8%-тай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн стандарт хангалт-80%, сумын эрүүл мэндийн төвүүд-83,9%, өрхийн эрүүл мэндийн төвүүд-94,5% байна. 2025 онд шинээр төгссөн их эмч-9, сувилагч-3, эх баригч-1, лаборант-1, Эрүүл ахуйч-1, өөр аймаг, сум, дүүргээс шилжин ирж ажиллаж байгаа 31 эмч, мэргэжилтнийг ажлын байраар хангасан. Хүний нөөцийн стандарт хангалтыг 2,3 хувиар нэмэгдүүлсэн. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлж, эмч мэргэжилтнүүдийн дунд ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр 2025 онд 12 арга хэмжээг зохион байгуулан 540 эмч ,сувилагч, эмнэлгийн ажилтнуудыг хамруулсан. хэрэгжилт 100 хувь
12	ЗДҮАХ-ийн заалт	2.2.2. Эмнэлгүүдийн эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	АЗДТГ, Говийн оюу хөгжлийг дэмжих сант хамтран БОЭТ-ийн 2 баг, Төвийн бүс: /ӨЭМТ-үүд, Хувийн хэвшил, ЗӨСТ, Өмнөд бүс: /Баян-Овоо ,Номгон, Хүрмэн, Цогтцэций/, Баруун бүс:/Гурвантэс, Ноён, Сэврэй,Баяндалай, Булган/, Зүүн бүс: /Ханбогд, Манлай, Цогт-Овоо,Мандал-Овоо,Ханхонгор/ Өмнөд бүс: /Баян-Овоо ,Номгон, Хүрмэн, Цогтцэций/ Нийт -6 багийн 24 сувилагч тусгай мэргэжилтэн оролцож амилуулах суурь тусламжийн гардан сургалтыг зохион байгуулсан. ЭМС-н 2024 оны А/387 тоот тушаалын дагуу Төвлөрлийг сааруулах Үндэсний баг Өмнөговь аймагт 3 дахь удаагаа ирж ажиллалаа. Зорилтот бүлгийн тусламж үйлчилгээ авах 756 иргэний бүртгэл мэдээллийг анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд гаргасан. Үндэсний баг 8 хоног ажиллаж Зүрх судасны эмчийн үзлэг-596, Мэдрэлийн эмчийн үзлэг-184 үүнээс мэдрэлийн ангиологи эмчийн үзлэг-36, Интервеншиналь радиологи эмчийн үзлэг-84, Хавдрын мэс засал эмчийн үзлэг-80, Хими эмчийн үзлэг-62 нийт 1006 өвчтөн үзэж зөвлөгөө өгсөн. Хавдрын судас бөглөх-8, Тархины судасны ангиографи- 5 Зүрхний титэм судсан дотуурх оношилгоо- 38 хүнд, Зүрхний титэм судсанд стент тавих буюу судас тэлэх эмчилгээ 16 хүнд хийгдсэн байна.Тархины судасны ангиографийн оношилгоог 6 хүнд хийснээс 2 хүн тархины судасны цүлхэн оношлогдсон. УБ хот руу УНТЭ-шилжүүлсэн.

			Элэгний хавдрын тэжээгч судас бөглөх эмчилгээг 8 өвчтөнд хийж 1 үйлчлүүлэгчийн элэгний буглаанд гуурс тавьж хавдрын Хөхний биопси -2 хүнээс авсан. Судсан дотуурх оношилгоо эмчилгээ, мэс ажилбарыг 7 төрлөөр 57 өвчтөнд үзүүлж судсан дотуурх оношилгоог 44 хүнд хийсэн. “Хавдрын эсрэг аян - 2025” арга хэмжээг Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 705 хүнд үзлэг оношилгоо хийж шинээр 12 хавдар, хавдрын урьдал 42 илрүүлсэн. 12 шинээр илэрсэн хавдрыг ХСҮТ-д онош тодруулахаар илгээсэн. Үүнээс элэгний хавдар 5, ходоодны хавдар 1, улаан хоолойн хавдар 1, хөхний хавдар 1, умайн хүзүүний хавдар 2 онош батлагдаж, 2 нь хавдрын онош үгүйсгэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ангиографийн тусламж үйлчилгээний дараа хянах хэсгийг тохижуулан ашиглалтад оруулсан. “Хавдрын эсрэг аян - 2025” арга хэмжээг ХӨСҮТ хамтран зохион байгуулсан. хэрэгжилт -100 хувь
13	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.14. Агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол зэрэг орчны нөлөөллөөс шалтгаалсан өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилтот төсөл, хөтөлбөрийг уул уурхайн нөлөөлөл бүхий сумдад төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлнэ.	Орон нутгийн санхүүжилтээр "Өнөөдрийн хяналт-Ирээдүйн хамгаалалт" уриан дор явуулын үзлэг арга хэмжээг Ноён, Гурвантэс, Мандал-овоо, Баян-овоо, Хүрмэн, Цогтцэций сумдад зохион байгуулан давхардсан тоогоор нийт 4,247 иргэн хамрагдсанаас 1093/25.7%/ малчид байна Говийн Оюу Хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр "Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд Эрүүл зүрх арга хэмжээнд Ханхонгор, Баяндалай, Мандал-овоо, Сэврэй, Ноён, Баян-овоо, Номгон суманд зохион байгуулж 342 иргэн хамрагдсан. Үзлэгээр зүрх судасны өвчлөл 65%, Чихрийн шижин болон бодисын солилцооны эмгэг 20% бусад өвчлөл 15% илэрсэн байна. Лавлагаа шатлалд онош тодруулах 13 иргэн, ангиографи 18 иргэн хамрагдахаар дараагийн шатлалд шилжүүлсэн. Хилийн боомтын бүс нутгийн суурин болон хөдөлгөөнт хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж, өвчлөлийг эрт илрүүлж эмчлэн эрүүлжүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх явуулын үзлэг арга хэмжээг Гашуун сухайн хилийн боомт, Цагаан хад суурьшлын бүсэд зохион байгуулсан. үзлэгээр нийт 1670 иргэн хамрагдсан.Үүнд Дотор 250, Гэмтэл 45, Арьс харшил 96, Нүд 154, Чих хамар хоолой 188, халдварт 145, Рентген 212, ЭХО 267, Хүүхэд 49, Шинжилгээ 264 хүн хийгээд байна. Үзлэгт хамрагдсан иргэдээс тээврийн

		жолооч 1100 /65,9%/, төрийн албан хаагчид 300 /17,9%/ бусад нь суурьшлын бүсийн иргэд байна. Мөн эрэгтэйчүүдээс 1090/65,3%/, эмэгтэй 580 /34,7%/ үзүүлсэн бол анхан шатлалд шилжүүлсэн 113 /6,7%/, лавлагаа шатлалд шилжүүлсэн 67 /4%/ байна. Халдвартад бэлгийн замын далд халдвар илрүүлэх PCR шинжилгээг 95 иргэнд хийж Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинжлүүлж байна. Мөн Тэмбүүгийн 4 тохиолдол, шинж тэмдэгтэй заг хүйтэн 1, шинж тэмдэгт үтрээний үрэвслийн 10 тохиолдол илрүүлсэн. Явуулын тусламж үйлчилгээг Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 13 чиглэлийн 58 эмч, мэргэжилтэн 11 суманд зохион байгуулж ажилласан. 2025 онд нийт 11 сумын 7595 иргэнд хүрч үйлчилсэн байна. хэрэгжилт 100 хувь
14	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.13. Эх хүүхдийн хоол тэжээлд дэмжлэг үзүүлэх "Сүү тараг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2025-2028 онд хэрэгжүүлэх "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 4/15 дугаар тогтоолоор "Сүү тараг" хөтөлбөрийг баталж 1 хүүхдэд сард ноогдох санхүүжилт 27,500 төгрөгөөр тогтоож, сард 4 удаа, нэг удаад 650 гр тараг, 600 гр сүүг эцэг эх, асран хамгаалагч нарт хуваарийн дагуу олгон ажилласан. Хөтөлбөрийн хүрээнд хамрагдвал зохих 6-12 сартай 4106 хүүхэд, 2 хүртэл насны ихэр 268 хүүхэд, 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1561 хүүхэд, жингийн алдагдалтай, 12-24 сартай жингийн алдагдалтай өсөлтийн хоцролттой 834 хүүхэд буюу нийт давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 6769 хүүхдийг 100% амжилттай хамруулан ажилласан. "Сүү тараг" хөтөлбөрийн санхүүжилтийг харьяа сумын Засаг даргын Тамгын газарт эрхийг шилжүүлэн нийт 186,147,500 сая төгрөг санхүүжилтийг олгосон Хөтөлбөрийн санхүүжилтээр зорилтод бүлгийн хүүхдүүдийн дунд зуны сувиллыг Баяндалай, Гурвантэс, Манлай, Сэврэй, Цогт-овоо СЭМТ-үүд ажиллуулан 220 хүүхдийг, Даланзадгад сумын 3 өрхийн эрүүл мэндийн 6-36 сартай жингийн алдагдалтай, хоол тэжээлийн дутагдалтай зорилтот бүлгийн 60 хүүхдийг Бумбардай зуны сувилалд хамруулж нийт 280 хүүхдийг 10 хоног хугацаатай хамруулсан. Цогт-Цэций, Ханбогд, Ноён сумын ЭМТ-үүд өөрийн санхүүжилтээр 285 хүүхдийг зуны сувилалд хамруулсан. Нийт тайлант онд 565 хүүхдийг зуны

			сувилалд хамруулан үр дүнд жин багатай, хоол тэжээлийн дутагдалтай болон жингийн алдагдалтай хүүхдүүдийн жин 400-845 граммаар нэмэгдэж нийт хамрагдсан хүүхдийн 53.6% жин нэмсэн, жингийн алдагдалтай өсөлтийн хоцролттой 834 хүүхэд 6 сарын дараа давтан үзлэгт хамруулахад 641 хүүхэд буюу 76,8% нь 1-1,260 гр жин нэмж жингийн алдагдал, өсөлт хоцрогдлоос гарсан үр дүнтэй хэрэгжилт 100 хувь
15	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.12. Эх, хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2025-2028 оны хооронд Эх, хүүхдийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь 3 зорилт 19 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн.хөтөлбөрийн хүрээнд давтагдсан тоогоор нийт 386 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг танхимын болон ажлын байрны онол, арга зүйн сургалтад хамруулсан. Цахимаар нийт 150 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд цаг үеийн мэдээлэл болон БОЭТ-ийн зөвлөх эмч нараар мэдээлэл хүргүүлж, арга зүйн сургалтад хамрагдсан. Аймгийн хэмжээнд нярайн скрининг хийх баг бэлтгэгдэж, онол арга зүйн сургалтад дүрс оношилгооны эмч, хүүхдийн эмч, сувилагч, нярайн сувилагч нар хамрагдсан. Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар 1012 эх амаржиж 1022 хүүхэд мэндэлсэн ба төрөлт өмнөх үеийн мөн үеэс 79 тохиолдлоор буурсан байна . 11 сарын байдлаар нийт 17 нярайд сурфактант эмчилгээ хийж, үүнээс-11 тохиолдол нь амжилттай болж, сэхээрлийн хувь нь 64,7%-тай байна. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтээр Эхийн эндэгдэл-0 Жирэмсний хяналтын хувь 91 Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хамрагдсан хяналтын хувь-93,2 Нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд-13,7 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-19,6 Перинаталь эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд-10,9 Жирэмснээс сэргийлэх арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн хувь-44 Үр хөндөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд-344 байна хэрэгжилт 94.9 хувь

16	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.11. Эрэгтэйчүүд, хөвгүүдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Өнөөдрийн хяналт- Ирээдүйн хамгаалалт" уриан дор явуулын үзлэг арга хэмжээг Ноён, Гурвантэс, Мандал-овоо, Баян-овоо, Хүрмэн, Цогтцэций сумдад зохион байгуулан давхардсан тоогоор нийт 4247 иргэн хамрагдсанаас 1093/25.7%/ малчин иргэн байна. Үзлэгт хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл нийт эрэгтэй 1462 /34,4%/, эмэгтэй 2785 /65,5%/ хамрагдсан байна. Өмнө жилтай харьцуулахад эрэгтэйчүүдийн тоо 4,4%-иар өссөн ба эрэгтэйчүүдийн дундах өвчлөл 41,3% байна. Бусад үзлэгээр Урьдчилан сэргийлэх үзлэгийг 150 иргэнийг хамруулсан эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулж үүний дүнд 35 иргэн Элэгний В вакцин хийсэн, Эдийн шинжилгээ шаардлагатай 1, Дурангийн хагалгаа шаардлагатай 3, Онош тодруулах шаардлагатай 1, Фимозын ажилбар 2, Даралт ихсэлттэй 11 иргэнд зөвлөгөө өгсөн. ПСР шинжилгээнд нийт 55 хүн хамрагдсан үүнээс 14 хүн буюу 25,4% нь малчин иргэд , 7 хүн буюу 12,7% нь ганц бие хүмүүс , 48 хүн буюу 82,7% нь гэр бүлтэй иргэд байна. Шинжилгээг дүгнэхэд 40 /72,7%/ хүн ямар нэгэн бэлгийн замаар дамжих далд халдвартай , 7 хүн бэлэг эрхтэний үрэвсэлт өвчинтэй , 8 хүн эрүүл байна. Өмнөговь аймгийн насанд хүрсэн хүн амын 17.4% нь тамхи татдаг бөгөөд эрэгтэйчүүдийн дунд тамхины хэрэглээ эмэгтэйчүүдээс 21.1 дахин их байна. Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь нийт тамхи татдаг хүмүүсийн 82.1%-ийг эзэлж байна. Тамхи татаж эхэлсэн нас дунджаар 20.6 байна. Ханбогд, Ханхонгор, Сэврэй, Номгон, Булган, Цогтцэций, Хүрмэн, Гурвантэс сумуудад тамхи татдаг хүн амын хувь аймгийн дундаж (17.4%)-аас өндөр байна. Өмнөговь аймгийн насанд хүрсэн хүн амын сүүлийн 1 сард стандарт уултаас илүү архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын хувь 8.5% байх бөгөөд эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ эмэгтэйчүүдээс 4.7 дахин их байна. Насанд хүрэгчдийн 22.5% артерийн даралт ихсэлттэй буюу САД нь 120-129 мм ба/эсвэл ДАД≤80 мм байв. Артерийн даралт ихсэлтийн тархалт эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эрэгтэйчүүдийн дунд өндөр байна (p<0.0001). Хэрэгжилт 100 хувь
17	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.10. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн кабинет Даланзадгад суманд байгуулна.	"Өнөөдрийн хяналт- Ирээдүйн хамгаалалт" уриан дор явуулын үзлэг арга хэмжээг Ноён, Гурвантэс, Мандал-овоо, Баян-овоо, Хүрмэн, Цогтцэций сумдад зохион байгуулан давхардсан тоогоор нийт 4247 иргэн хамрагдсанаас 1093/25.7%/ малчин иргэн байна. Үзлэгт хамрагдсан иргэдээс эрэгтэй 1462 /34,4%/, эмэгтэй 2785 /65,5%/ хамрагдсан Өмнө онтой

			харьцуулахад эрэгтэйчүүдийн тоо 4,4%-иар өссөн ба эрэгтэйчүүдийн дундах өвчлөл 41,3% байна. Цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгээр өвчний улмаас цэргийн албанд тэнцээгүй 245 иргэнээс Халдварт өвчин-9, бусад өвчлөл-236 байгаа бөгөөд эрүүлжүүлэх арга хэмжээг тус иргэдэд зохион байгуулж харьяа анхан шатны ЭМБ-уудад хүргүүлсэн урологи-андрологийн кабинетэд 237 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 180 хүнд мэс ажилбар хийж эрүүлжүүлсэн. Хэрэгжилт 100 хувь
18	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.9. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан орон нутагт эрүүл зүй, урьдчилан сэргийлэх лаборатори байгуулна.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль 2024 онд батлагдан гарсантай холбогдуулан аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийг тусад бие даасан байгууллага байхаар хуульчилсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулинд аймгийн нийгмийн эрүүл мэндийн төв нь эрүүл зүй, урьдчилан сэргийлэх лабораторийн үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг тусгагдсан байдаг. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн төв барилга байгууламжийн зураг төсвийн боловсруулан баталсан бөгөөд барилга байгууламжид лабораторийн орчин нөхцөлийг тусгасан. 2025 онд Эрүүл мэндийн яаманд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт сайжруулахтай холбоотойгоор аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн лабораторийг байгуулж орчин, хор судлал, микробиологийн шинжилгээ хийх чадамжтай лабораторийг үе шаттайгаар байгуулах, үндэсний тогтолцоог бий болгох саналыг хүргүүлсэн
19	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.8. Өсвөр насныхан болон насанд хүрэгчдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох цогц нөлөөллийн ажил зохион байгуулна	1. Эрүүл мэндийн яамны А/376 дугаар тушаалын дагуу 0-17 насны багцын эрт илрүүлэг 11,800 хүүхдээс 10,100 үзлэгт хамруулан 85.5 хувьтай байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн өсвөр үеийн кабинет 2025 онд 1825 хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан үүнд Өсвөрийн үеийнхний дунд бэлгийн замаар дамжих халдварын 56 тохиолдлыг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлсэн. Өсвөр үеийн үр хөндөлтийн 17 тохиолдол, бэлгийн хүчирхийллийн шинжтэй 13 тохиолдолд, жирэмслэлтийн 32 тохиолдолд Умайн хүзүүний үрэвсэл болон бусад үрэвслийн шалтгаант өвчлөл -54 тохиолдлыг эмчлэн эрүүлжүүлж урьдчилан

		сэргийлэх үзлэг шинжилгээнд -514, бусад өвчлөлөөр нийт 1202 хүүхэд тусламж үйлчилгээ авч үзлэг шинжилгээнд хамрагдсан. Ерөнхий боловсролын өсвөрийн клубын сурагч нарт Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 6-р сургуулийн 26 сурагчид зохион байгуулагдсан. Өсвөр үеийн 23 клубын сурагч багш нараар дамжуулан 6-12 дугаар ангийн 3,300 сурагчдад мэдлэг олгох зорилгоор 10 дугаар сарыг Осол гэмтлээс сэргийлье, 11 дүгээр сарыг сэтгэцийн эрүүл мэнд, 12 дугаар сарыг Бэлгийн замын халдвараас сэргийлье сэдвээр мэдээллүүдийг өгч Өсвөр үеийн сургагч клубуудын дунд Мэдлэгтэй хүүхэд аяныг зохион байгуулан ажилласан. 2025 онд сургууль, цэцэрлэгийн хүрээнд “Энэ жилдээ Эрүүл жиндээ” хатариш бүжгийн аяныг зохион байгуулж 12 сургууль 15 цэцэрлэгийн 9500 хүүхэд идэвхтэй оролцсон. Эрүүл мэндийн массын олимпиадыг зохион байгуулж аймгийн ерөнхий боловсролын сургуулийн VI-XII ангийн 2,794 сурагч, эрүүл мэндийн хичээл зааж буй 56 багш нийт 2,850 хүнийг хамруулан эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн. Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээнийг алслагдсан суманд анх удаа зохион байгуулж Ханбогд сумын ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургуулийн 4-7 дугаар ангийн 9 баг 72 сурагч, 18 багш оролцсон. Тэмцээний дүнд хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг, чадвар 63.5% байсан тэмцээний төгсгөлд 82.1% хувь болж 18.6% хувиар нэмэгдсэн эерэг үр дүнтэй байна. Хэрэгжилт 100 хувь
20	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.7. Бөөр, шээс, бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх зорилтот аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулна. Халдварт өвчний 1389 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 180.4 байна . Халдварт өвчний шалтгаант нас баралт -2 бүртгэгдсэн. Нийт халдварт өвчний 539 /38.8%/-г БЗДХ, 244 /17.6%/-г салхинцэцэг, 379 /27.3%-г улаанбурхан өвчин, 72 /5.2%/-г хоолны хордлого, 38 /2.7%/-г цусан суулга, 20 /1.4%/-г улаан эсэргэнэ, 60 /4.3%/-г гар хөл амны өвчин, 6 /0.4%/-г ёлом, 20 /1.4%/-г сүрьеэ, 2 /0.1%/-г вируст гепатит, 4 /0.3%/-г сальмонеллт, 1 /0.1%/-г арьс мөөгөнцөртөх өвчин, 2 /0.1%/-г халдварт эритема, 1 /0.1%/-г менингококкцеми тодорхойгүй, 1 /0.1%/-г -толбот чичрэг зэрэг өвчнүүд тус тус эзэлж байна. Жирэмсний хяналтад 1227 эх хяналтад авснаас орсны 1023 (92,7%) эхний 3 сартайд, 104/9,2%/ нь хожуу хяналтад орсон байна Жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын өвчлөл тэмбүүгийн халдварын 6 эерэг

			тохиолдол, бүртгэгдэж эмчилгээнд хамрагдсан. Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.6% хамрагдсан, трихомониаз илрүүлэх шинжилгээнд 92.0% нь хамрагдаж, эерэг тохиолдол бүртгэгдээгүй байна.БЗДХ-г илрүүлэх, урьдчилан сэргийлэх, зорилгоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 7,391 хүнд хурдавчилсан сорил хийг эерэг илэрсэн тохиолдлыг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад онош тодруулах болон эмчилгээнд хамруулсан. ШУТИС-ын Өмнөговь аймаг дахь салбар Техникийн их сургуулийн киос хөтөлбөрийн 81 оюутанд халдварт өвчний эрт илрүүлэг шинжилгээнд хамруулахад БЗДХ-н өвчлөл бүртгэгдээгүй. Хилийн боомтын бүс нутгийн суурин болон хөдөлгөөнт 1670 иргэнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан. Үүнээс бэлгийн замын далд халдвар илрүүлэх PCR шинжилгээг 95 иргэнд хийж Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинжлүүлсэн. Мөн Тэмбүүгийн 4 тохиолдол, шинж тэмдэгтэй заг хүйтэн 1, шинж тэмдэгт үтрээний үрэвслийн 10 тохиолдол илэрсэн байна. Илэрсэн 539 өвчлөлийг 100 хувь бүрэн эмчилгээнд хамруулж, тархвар судлалаар хавьтагчийг 30 хувийг илрүүлж эмчилгээнд хамруулсан. Хэрэгжилт 100 хувь
21	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.6. Хими эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, бай эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.	Аймгийн хэмжээнд хорт хавдраар оношлогдсон нийт 618 тохиолдлыг хяналтад байгаагаас 2025 онд 55 хавдрын шинэ тохиолдлыг илрүүлж, илрүүлсэн хавдрын 18.1% хувийг эрт шатанд илрүүлж хяналтад авч эмчилж байна. Хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр Хавдар судлалын үндэсний төвийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран үндэсний баг үзлэг арга хэмжээг зохион байгуулан 233 хүнийг лавлагаа шатлалын үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулсан. Арга хэмжээний үеэр БОЭТ-ийн Хавдрын эмч, Ангиографийн эмч нар ажлын байрны дагалдан сургалтад хамрагдаж чадавхажсан. БОЭТ-ийн дотрын тасгийн 2 сувилагчийг Хавдар судлалын үндэсний төвд хавдрын хими, бай, хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр 1 сарын хугацаатай ажлын байрны дагалдан сургалтад хамруулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан. Мөн Хөнгөвчлөх эмчилгээний эмчээр богино хугацааны сургалтад 1 эмч хамрагдаж төгссөн байна. Хавдрын хими, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдаж буй иргэдэд долоо хоног бүрийн лхагва гаригт 11-12 цагийн хооронд хөгжимт засал эмчилгээг уламжлал болгон зохион байгуулж байна. 0-18 насны хавдраар оношлогдсон хүүхдүүд болон

		тэдгээрийн гэр бүл асран хамгаалагчид нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ар-Үр” сувилалтай хамтран 20 хүнийг хүүхдийн хамт эмчилгээ, сувилгаанд хамруулсан. Хавдрын эсрэг аяны арга хэмжээг зохион байгуулж үзлэгт 705 хүнд үзлэг оношилгоо, шинжилгээ хийж хавдрын урьдал, сэжигтэй тохиолдол 42, шинээр хавдрын 12 тохиолдлыг илрүүлсэн. Үзлэгийн үр дүнд хяналтын үзлэг 131, эсийн шинжилгээ 73, эдийн шинжилгээ 6, хийгдсэн мэс ажилбар 1, анхан шатны эмчийн хяналтад 223, КТГ 39, дурангийн шинжилгээ 20 хүнд тус тус хийж тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажилласан. Нийт 12 шинээр илэрсэн хавдрыг ХСҮТ-д онош тодруулахаар илгээсэн. Үүнээс элэгний хавдар 5, ходоодны хавдар 1, улаан хоолойн хавдар 1, хөхний хавдар 1, умайн хүзүүний хавдар 2 онош батлагдаж, 2 нь хавдрын онош үгүйсгэгдсэн байна. Шим билэг, Цогтцэций, БОЭТ-д умайн хүзүүний өвчлөл, хавдрыг эрт илрүүлэх колькоскопныг ашиглан 131 хүнд тусламж үйлчилгээг үзүүлж үзлэгээр умайн хүзүүний хавдрын урьдал байх магадлалтай 15 хүн буюу нийт үзлэгийн 15,6%-эсийн шинжилгээнд хамруулсан байна. Үүнээс умайн хүзүүний хавдрын урьдлаар 2 хүн оношлогдож шаардлагатай эмчилгээ, зөвлөмжийг хүргүүлэн хяналтад авсан. Эмэгтэйчүүдэд зонхилон тохиолдох хавдрыг эрт илрүүлэх зорилгоор Даланзадгад сумын 195 эмэгтэйчүүдэд үзлэг шинжилгээ, оношилгоо зохион байгуулсан. Үүнээс 19 эмэгтэй CIN I-II зэргийн оноштой 3 эмэгтэй хавдрын урьдал өвчнийг илрүүлж, БОЭТ-ийн эмэгтэйчүүдийн тасагт 3 эмэгтэй хагалгаанд орсон 1 эмэгтэй ХСҮТ-дээр хагалгаанд орж эмчлэн эрүүлжүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Гурвантэс сумын эрүүл мэндийн төвд эрт илрүүлгийн үзлэг оношилгоонд хиймэл оюун ухаанаар /Cervigary AI/ технологийг тогтмол ашиглан 235 эмэгтэйд тусламж үйлчилгээг хүргэж, умайн хүзүүний хавдрын 2 тохиолдлыг оношилж ХСҮТ-д шилжүүлсэн. Хавдрын эсрэг аян, умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлэх үзлэгт нийт - 1368 Ажлын байрны дагалдан сургалтад хамруулсан эмч, мэргэжилтний тоо – 15 Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо - 92 Хими эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-15 хүнд 52 удаа Бай эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо – 8 хүнд 24 удаа Хавдрын өвчлөл 10000 хүн амд 7.1 промил байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 3.1 промилээр буурсан байна. Хэрэгжилт 100 хувь
--	--	---

22	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.5.Шүд цооролтын тархалт, шүдний өвчлөлийгбууруулах, дадал хэвшлийг олгох "Эрүүл шүд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	“Эрүүл шүд” хөтөлбөрийг боловсруулан АИТХ-н хурлаар батлуулсан. Хөтөлбөрийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нийт 10 үйл ажиллагааг төлөвлөн 95% биелэлттэй хэрэгжүүлсэн. Аймгийн хэмжээнд сумын эрүүл мэндийн төв 8 /Гурвантэс, Манлай, Ноён, Номгон, Ханбогд, Цогтцэций, Сэврэй, Баяновоо/ шүдний кабинетаар, 7 сумын эрүүл мэндийн төв шүдний хувийн хэвшлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж амны хөндийн тусламж үйлчилгээг тогтмол хүргэж байна. Өмнөговь аймгийн Засаг даргын "Өсөлттэй Өмнөговь" хөтөлбөрийн "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд "Нүүдэлчдийн инээмсэглэл" төрийн бус байгууллагатай хамтран шүдний тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, тулгамдсан асуудлыг хэлэлцэх хэлэлцүүлэг, сургалтыг Өмнөговь аймагт ажиллаж буй шүдний 35 эмч, мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг, Говь дент ОНӨААТҮГ, БОЭТ зэрэг 18 кабинетаар амны хөндий, шүдний тусламж үйлчилгээг нийт 36,985 хүнд үйлчилгээ үзүүлэн эмчлэн эрүүлжүүлсэн 21,148 /85,9%/ байна. үүнээс өвчний учир 24,620 урьдчилан сэргийлэхээр 12,365 иргэнд үйлчилгээ хүргээд байна. Өнгөрсөн онтой харьцуулахад тусламж үйлчилгээ хүргэсэн хүний тоо 4.3 хувиар нэмэгдсэн бол урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүний тоо 14%-иар өссөн нь өвчлөлийг хүндрэхээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшин дээшилсэн байна. Говь Дент анхны цахиур ОНӨААТҮГ нь 2025 онд шүдний тусламж үйлчилгээг нийт 20,567 хүнд үзүүлсэн бөгөөд үүнээс өвчний учир 6,920, урьдчилан сэргийлэх үзлэг 13,647 хүнд үнэ төлбөргүй зохион байгуулсан. Мөн сар бүрийг нэрэмжит сар болгон зарлаж зорилтот бүлэгт чиглэсэн үзлэгийг зохион байгуулан 1,329 иргэнийг хамруулсан. үүнд хүүхдэд зориулсан сар, өндөр настанд, тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан, тамирчин хүүхдүүдэд гэх мэт үзлэгүүдийг зохион байгуулсан байна. Орон нутгийн хэмжээнд 24/3 шүдээ угаа аяныг сум, өрх бүр зохион байгуулж, нийт 6005 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг, фтор түрхлэг хийсэн ба үзлэгээр цоорлын тархалт 82%, цоорлын эрчим 4.5% байна. Мөн Даланзадгад сумын хэмжээний цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийхэд, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн шүд цоорлын тархалт 72,9%-тай, цоорлын эрчим 4,4 тай, сургуулийн насны хүүхдүүдийн дунд шүд цоорлын тархалт 77,4%-тай шүд цоорлын эрчим 4,3 тай байна. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт
----	-----------------	--	---

			нөлөөллийн арга хэмжээнд 19,849 иргэн, хүүхэд өсвөр үеийнхэн хамрагдсан байна. Хэрэгжилт 100 хувь
23	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.4.Элэгний шалтгаант өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор "Эрүүл элэг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 4/16 тогтоолоор “Эрүүл элэг” (2024-2028 он) орон нутгийн дэд хөтөлбөрийг батлуулсан. “Элэг бүтэн монгол” арга хэмжээ, “Эрүүл элэг” орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 15-65 насны 25,489 зорилтод хүн амын 16941 буюу 66,5 хувийг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан. 0.04% буюу 6 нь С вирустэй, 0.04 % буюу 7 нь В вирусийн архаг, шинэ тохиолдлыг илрүүлэн эрүүл мэндийн байгууллагын хяналтад авсан. Цочмог С вирусийн халдвартай 1, В вирусийн халдвартай 1 хүн тус тус бүртгэгдээд байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн PCR шинжилгээнд нийт 433 хүн шинжилгээ хийж HCV вирус 42.9% буюу 186 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 130 (70.8 %) идэвхтэй 56 (29.2%), HBV вирус 42.7% буюу 189 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 165 (86.2%) идэвхтэй 24 (13.8%) , HDV вирус 14.3% буюу 56 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 28 (50%) идэвхтэй 28 (50%), HBV&HDV хавсарсан вирустэй (0.08 %) хүмүүс хамрагдсан байна. Элэгний С вирусийн эмчилгээнд хамрагдах шаардлагатай 56 иргэнээс 27 иргэнийг эмчилгээнд бүрэн хамруулж, 15 хүнийг хяналтад хамрагдаж, 10 хүн эдгэрсэн. Үүнд жирэмсэн 3 хүн эмчийн хяналтад орсон. Элэгний В вирусийн эмчилгээнд 43 хүн шинээр орж, шинээр 10 хүн хяналтад орж нийт 29 хүн эмийн эмчилгээнд тасралтгүй хамрагдаж байна. Үүнд жирэмсэн 7 эх эмчийн хяналтад орсон. Элэгний В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 1147 хүн тун хийгдэж, үүнээс 137 хүн бүрэн тунд хамрагдаад байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Фиброскан аппарат 460 хүнд тусламж үзүүлснээс F0 зэрэгтэй 211, F1 зэргийн элэгний хатууралтай 130, F2 зэргийн элэгний хатууралтай 78, F3 зэргийн элэгний хатууралтай 19, F4 зэргийн элэгний хатууралтай 22 зэргийн оношлон шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэсэн. Мөн элэгний өөхлөлттэй 30 иргэнийг оношилж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Эмчилгээнд хамрагдалт-74,1 хувь Хэрэгжилт 97,5 хувь

24	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.3.Аймгийн хэмжээнд 0-18 хүртэлх насны хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.	Аймгийн хэмжээнд 4,6,8,10,12,14,16,17 хүртэлх насны 11,888 хүүхдийн судалгааг нэгтгэж урьдчилан сэргийлэх үзлэгт 85 хувь хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх “Жаргалтай ирээдүй” төсөл арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээнд шаардлагатай 287,714,000 төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Жаргалтай ирээдүй хүүхдийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үзлэгийн бүртгэл, мэдээлэл, тайланг боловсруулах тусгайлсан программыг хөгжүүлсэн. Аймгийн 14 СЭМТ, 3 ӨЭМТ нийт 11,888 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаас одоогийн байдлаар 8,741 хүүхэд үзлэгт хамрагдсан бөгөөд үзлэгийн хамрагдалт 73.5 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж тайлант онд үзлэгийг 100 хувь хүргэнэ. Үзлэгийн үр дүнд хамрагдсан хүүхдүүдийн 32 хувь (2813) хувьд нь амны хөндийн өвчлөл, 17.9 хувь (1570) хувьд нь нүдний эмгэг, зүрхний цахилгаан бичлэгээр өөрчлөлттэй 11.7 хувь (1024) хувьд өөрчлөлт илэрсэн байна. Шинжилгээгээр А бүлгийн стрептококкын халдвар эерэг 6 хувь (530) хувьд, сахар өөрчлөлттэй 1.8 хувь (158) хувь, өөх тос өөрчлөлттэй 0.9 хувь (79) хувьд тус тус өөрчлөлт илэрсэн байна. Мөн нийт хүүхдийн 15.9 хувь (1395) эрдэс /Д,Fe,Ca/ дутагдалтай, 13.5 хувь (1188) хувьд нь хеликобактер илэрсэн. Элэгний В,С вирус илэрсэн 26, БЗДХ илэрсэн 6, хөвгүүдийн үзлэгээр ивэрхий, фимоз илэрсэн 23, охидын үзлэгээр өөрчлөлттэй 1 тохиолдол тус тус илэрсэн байна. Ерөнхий эмчийн дүгнэлтээр лавлагаа шатлалд шилжүүлсэн 405, эмчлэн эрүүлжүүлсэн 136, эмчилгээ хийгдэж байгаа 384 тохиолдол байна. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй 6 настны эрт илрүүлэг үзлэгийн хувьд нийт 1,929 хүүхэд хамрагдахаас зүрхний үзлэгт 1,363 /70,6 хувь Шүдний үзлэгт 1,594/82,6 хувь/ нүдний үзлэг хэрэглэгдэхүүний хүрэлцээгүй байдлаас болоод 413 /21,4 хувь/-тай тус тус хамрагдсан. Хэрэгжилт 100 хувь
25	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.2. Эрт илрүүлэг нэгдсэн төв, оношилгооны иж бүрэн лабораторийг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлнэ.	Эрүүл мэндийн сайдын 379 дүгээр тушаалын хүрээнд үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй эрт илрүүлэг үзлэгт 29,331 хүнийг хамруулж нийт хамрагдвал зохих хүн амын 40% хувь нь хамрагдсан. Насны бүлгээр авч үзвэл 0-5 насанд 6101 /57,8%/, 6-17 насанд 12876 /74%/, 18-30 насанд 2588 /19,4%/, 31-45 насанд 3702 /20,2%/, 46-60 насанд 2861 /27,0%/, 61+ насанд 1203 /24,7%/ хамрагдалттай байна. Эрт илрүүлэг хийх чадамжтай эрүүл мэндийн байгууллагыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Жасминдра хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж, 1200 гаруй иргэнийг эрт илрүүлэг хамруулсан.

			Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрт илрүүлгийн дэмжих төвийн хүчин чадал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж өдөрт 50-60 иргэнд түргэн шуурхай, тав тухтай үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Эрт илрүүлэг хийх эмч мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлэн 2 ходоодны дуран, 1 дурангийн эмч, 1 сувилагч нэмэгдүүлэн тогтвор суурьшилтай ажиллаж байна. .хэрэгжилт-100 хувь
26	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1.1. Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо эмчилгээг зохион байгуулна.	Эрүүл мэндийн сайдын 379 дүгээр тушаалын хүрээнд үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж буй эрт илрүүлэг үзлэгт 29,331 хүнийг хамруулж нийт хамрагдвал зохих хүн амын 40% хувь нь хамрагдсан. Насны бүлгээр авч үзвэл 0-5 насанд 6101 /57,8%/, 6-17 насанд 12876 /74%/, 18-30 насанд 2588 /19,4%/, 31-45 насанд 3702 /20,2%/, 46-60 насанд 2861 /27,0%/, 61+ насанд 1203 /24,7%/ хамрагдалттай байна. Эрт илрүүлэг хийх чадамжтай эрүүл мэндийн байгууллагыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Жасминдра хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж, 1200 гаруй иргэнийг эрт илрүүлэг хамруулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрт илрүүлгийн дэмжих төвийн хүчин чадал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж өдөрт 50-60 иргэнд түргэн шуурхай, тав тухтай үйлчилгээ үзүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн эрт илрүүлэг хийх эмч мэргэжилтний нөөцийг нэмэгдүүлэн 2 ходоодны дуран, 1 дурангийн эмч, 1 сувилагч нэмэгдүүлэн тогтвор суурьшилтай ажиллаж байна. Эрт илрүүлгийн үр дүнд хоол боловсруулах замын эмгэгтэй 398 хүн, зүрх судасны өвчтэй 105 хүн, бөөр шээсний замын өвчтэй 99 хүн, БЗДХ өвчтэй 10 хүн, дотоод шүүрлийн өвчлөлтэй 36 хүн, элэгний вирустэй 65 хүнийг тус тус илрүүлэн хяналтад авч, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Хавдрын үүсгэвэр тодорхойлогдсон 37 хүнийг лавлагаа шинжилгээнд бүрэн хамруулсан. Эрүүл мэндийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу эрт илрүүлгийн арга хэмжээг түр хугацаанд зогсоогоод байна. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу хэрэгжиж буй Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдад нүд, шүд, зүрхний эмгэгийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгийг орон нутагт зохион байгуулсан. Зүрх-1-р шатны зүрхний цахилгаан бичлэгийн үзлэгт хамрагдвал зохих 1,924 хүүхдээс 1,734/90,1%/ хүүхдийн зүрхний цахилгаан бичлэг хийгдэж, 475/27,3%/

			хүүхдэд өөрчлөлт илэрсэн. 2-р шатны үзлэгт 475 хүүхэд хамрагдахаас 369/77,6%/ хүүхэд хамрагдаж, 18/4,8%/ хүүхдэд өөрчлөлт илэрч эмчийн хяналтад орох, зөвлөгөө мэдээлэл өгөх болон лавлагаа шатлалд шилжүүлсэн байна. Шүдний үзлэгт 1,857/91,3%/ хамрагдаж 1,175/66,8% илрүүлж 978/83,2%/ эмчлүүлсэн байна. Нүдний үзлэг хэрэглэгдэхүүний хүрэлцээгүй байдлаас болоод 672 /34,9%/ -тай хамрагдаж 90/13,3%/ илрүүлсэн байна. Хэрэгжилт 88.8 хувь
27	ЗДҮАХ-ийн заалт	2.2.1 хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн эрт илрүүлгийг нэмэгдүүлнэ	Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлгийн анхан шатны 17 эрүүл мэндийн байгууллага, БОЭТ хамтран хамрагдвал зохих 64588 хүнээс нийт 38468 хүнд буюу 59,5 хувийг хамруулсан үүнд: Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 15,835 хүн хамрагдсан буюу 57,8 хувь, Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 109 хүнд буюу 15,2 хувьд нь артерийн гипертензи онош батлагдан хяналтад байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт 35-аас дээш насны нийт 14,594 хүн буюу-73,4 хувьтай. Үр дүнгийн үзүүлэлтээр давтан үзлэгийн 20 хүнд буюу 4.0 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. “Диабетын төв” –ийг 2025 оны 11 сарын 04-нд байгуулсан .тус төв ашиглалтад орсноос хойш нийт 1310 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлснээс: Амбулаторийн үзлэгээр 1108 Нээлттэй хаалганы өдөрлөгөөр 52 Тайлангийн өдөрлөгт 150 хүнд хүрч үйлчилсэн байна. Амбулаториор үйлчлүүлсэн иргэдийн /1108/ 70.2% нь дотоод шүүрлийн эмгэгийн улмаас тусламж үйлчилгээ авсан байна. Үүнд: Чихрийн шижингийн хэв шинж 1,2 шалтгаанаар 301 буюу 27.2% Бамбайн эмгэгийн шалтгаант 414 буюу 37.7% Дотоод шүүрлийн бусад эмгэг 63 буюу 5.7% байна. Шинээр оношлогдсон өвчлөл: - Чихрийн шижин хэв шинж 2 шинээр оношлогдсон – 14 - Бамбайн хордлого шинээр оношлогдсон- 4 - Бамбайн дутагдал шинээр оношлогдсон- 7 - Өнчин тархины дутмагшил-1 - Чихрийн шижингийн урьдал байдал - 9

		- Чихрийн шижингийн хөлийн хүндрэл шалгах үзлэг - 15 - Инсулин хичээл – 3 - Хооллолтын зөвлөгөө – 32 үзүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж, оношилж, эмчилж, хяналтад авч ажилласан. Хөхний хавдар илрүүлэх үзлэгт 6457 иргэн буюу 53,1 хувьтай хамрагдсан. нь халдварын бус үзлэгт, үлдэх хувь нь бусад урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. - умайн хүзүүний эсийн шинжилгээнд 1572 хамрагдвал зохих иргэдийн 30,7 хамрагдсан байна. 11 сарын байдлаар: - Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг 57,8 (15,835) - Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг 73,4 (14,594) - Хөхний хавдрын эрт илрүүлэг 53.1 (6457) - Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг 30,7 (1572) Хэрэгжилт 100 хувь
--	--	---

**Нийт
дүн**